

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын хэсгийн 28 дугаар хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн 28 дугаар хуралдаан 2012 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 14 цагт Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Л.Гансүх, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Ашигт малтмалын газрын хэлтсийн дарга Г.Алтансүх, мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын төсөл хариуцсан мэргэжилтэн Б.Хулан, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын мэргэжилтэн С.Баярцэцэг, Газрын тосны газрын хэлтсийн дарга Б.Оюун, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Д.Дамба, "Оюу толгой" ХХК-ийн олон талт хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, "Эрдэс холдинг" ХХК-ийн нягтлан бодогч Э.Эрдэнэцэцэг, "Багануур" ХК-ийн Санхүүгийн хэлтсийн дарга Ч.Очирлхам, "Нээлттэй нийгэм форум" ТББ-ын менежер Н.Дорждарь, "Хил хязгааргүй алхам" ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, "Ил тод сан" ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, "Байгаль эхийн аврал сан" ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг, Монголын Байгаль орчны иргэний зөвлөлийн менежер М.Отгонцэцэг, "Онон улз голынхон хөдөлгөөн"-ий тэргүүн Л.Отгонцэцэг, Монголын байгаль хамгаалах холбооны удирдах зөвлөлийн гишүүн Д.Сэнгэлмаа, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 19 гишүүн оролцож ирц 58 хувьтай байв.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав, ахлах аудитор Н.Эрдэнэцог, ахлах аудитор Б.Мэндбаяр, аудитор Т.Отгонхүү, аудитор Л.Бадамцэцэг, аудитор Ц.Сарантунгалаг, аудитор Д.Басорбил, аудитор Д.Ахжоол, Гаалийн ерөнхий газрын улсын байцаагч Б.Булган, "Ариун суварга хөдөлгөөн"-ий тэргүүн Г.Чагнаадорж, ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа нар оролцов.

Э.Сумъяа: Сайн байцгаана уу. Гансүх дарга уулзалттай байгаа тул хуралд 30 минут хоцорч ирнэ, хурлаа эхлүүлж бай гэсэн тул ажлын хэсгийн хуралдаан эхэлснийг мэдэгдэе. Өнөөдөр 3 асуудал хэлэлцэнэ. Та бүхэнд хэлэлцэх асуудал болон дотоод журам урьдчилж очсон байгаа, хэлэлцэх асуудал, дотоод журмын талаар үг хэлэх, саналтай хүн байна уу? (Үг хэлэх хүн гараагүй болно.)

Хэлэлцэх асуудал, дотоод журмын санал байхгүй тул хэлэлцэх асуудлын дарааллын дагуу нэгдүгээр асуудлыг Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ерөнхий захирал Б.Осоргарав танилцуулна.

I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэл тайлангийн эцсийн дүгнэлтүүд, зөрүүний байдал

Б.Осоргарав: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Бид Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны нэгтгэл тайлангийн урьдчилсан танилцуулгыг 2012 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Ажлын хэсгийн хурлаар танилцуулж, түүнээс хойш хурлаас гарсан санал, зөвлөмжүүдийг тусгаж, үлдсэн шийдвэрлэгдээгүй

зөрүүнүүд дээр ажиллаад 2012 оны 11 дүгээр сарын 2-ны өдрөөр тасалбар болгож нэгтгэл тайлангийн эцсийн үр дүнг та бүхэнд танилцуулж байна. Танилцуулгыг самбар дээр гаргаж, дэлгэрэнгүй танилцуулав (Танилцуулгыг хавсаргав.).

Н.Дорждарь: Нэг зүйл асуух гэсэн юм. Тайлбарлагдаагүй зөрүү гэдэг дээр 724 сая төгрөг, 385 сая төгрөг гээд хоёр өөр тоо яваад байна. Энэ ямар учиртай юм бэ? Өөрөөр хэлбэл энэ бол нэг нь Засаг талдаа, нөгөө нь компани талдаа гарсан зөрүү учраас нийт зөрүү нь энэ хоёрын нийлбэр буюу 1 тэрбум гаруй төгрөг байх учиртай юм биш үү? Энэ цэвэр зөрүү, анхны зөрүү гээд энэ их олон зөрүүгийн талаархи олон янзын тоон мэдээлэл хүмүүсийн толгойг эргүүлээд байна. Эцсийн дүндээ үүнийг энгийн хүн уншиж, ашиглах учраас ойлгомжтой байх хэрэгтэй байна.

Н.Эрдэнэцог: Ер нь бол бид зөрүүг их олон янзаар харуулах гэж хичээсэн. Тэгээд хамгийн оновчтой нь энэ хувилбар юм. Өөрөөр хэлбэл тохируулга хийсний дараа Засгийн газар талдаа тайлбарлагдаагүй үлдсэн тэр 385 сая төгрөг гэдэг нь Засгийн газар хүлээн авсан гэдгээ нотлоод байхад компани талаас ямар нэгэн тайлбар өгөхгүй үлдсэн зөрүү гэсэн үг, харин тэр компани талдаа тайлбарлагдаагүй үлдсэн 724 сая төгрөг гэдэг нь компани энэ дүнг төлсөн гэдгээ нотлоод байхад Засгийн газар талдаа хүлээн авсан нь нотлогдохгүй үлдсэн зөрүү гэсэн үг юм. Тэгээд бид энэ дундаас цэвэр зөрүү гэдгийг гаргаж ирсэн. Яагаад гэвэл Засгийн газар талд илүү мөнгө байна, компанийн талд дутуу мөнгө байна, нөгөө талд компани талд илүү мөнгө байна, Засгийн газрын талд дутуу мөнгө байна, тэгээд 2 тайлангийн хасах, нэмэх талаа баланслуулахаар цэвэр зөрүү нь арай багасч харагдаж байгаа юм. Гэхдээ таны хэлдэгээр яг бодитой зөрүү нь хоёр тал тайлбарлаж чадахгүй үлдсэн тэр 385 сая, 724 сая төгрөг гээд нийлбэрээр нь авах нь зөв юм.

Н.Дорждарь: Бас нэг асуулт байна. Сая та бүхэн аймаг, аймгаар задлан харуулсан нэмэлт материал тарааж өглөө. Миний ойлгосноор жишээлбэл нэг компани газрын төлбөр гэхэд нэг л тоо гаргаж өгсөн байхад үүнийг яаж аймаг, аймгаар нь салгаж авсан бэ?

Б.Мэндбаяр: Анх хоёр талаас мэдээлэл ирэхэд эхлээд тоонууд нэг дүнтэй байдаг. Үүнийг бид жишээ нь "Оюу толгой" ХХК гэхэд газрын төлбөрт 500 сая төгрөг төлсөн байвал үүнийг хэдэн сарын хэдний өдөр, ямар харилцагч руу шилжүүлсэн бэ гээд дэлгэрэнгүй хуулгыг компаниас нь авдаг. Энэ дүнгээ эргүүлээд Засгийн газрын мэдээлэлтэй тулгадаг, хэрэв зөрүү үүсвэл бид аймагтай нь холбогддог. Ингээд аймаг, сум бүр рүү хандаад ирэхээр мэдээлэл их дэлгэрэнгүй гарч ирдэг. Ингэж задарч гарч ирсэн мэдээллээ бид аймаг, орон нутгаар нь ангилаад та бүхэнд танилцуулж байгаа юм.

Э.Сумъяа: Надад нэг асуулт байна. Та бүхэн Татварын ерөнхий газар гээд нэгдсэн дүнгээр нь яриад байна. Гэтэл татварын байцаагч гэдэг хүн татвар хураагаад, дараа нь үүнийгээ журмын дагуу өөр хооронд нь шилжүүлдэг юм байна лээ. Өөрөөр хэлбэл тухайн нэг компаниас тэдэн төгрөгний аж ахуйн нэгжийн орлогын албан татвар авна гэж төлөвлөсөн байгаад, тэр компани нь илүү төлсөн бол тухайн компанитайгаа тохироод илүүг нь нэмэгдсэн өртгийн албан татварт тооцоод авлаа гээд хооронд шилжүүлдэг юм байна лээ. Энэ одоо хэвээрээ юу? Үүнийг та бүхэн ажигласан уу?

Б.Мэндбаяр: Тийм. Ийм асуудал гардаг. Компани бол татвар бүрээр салгаад тайлагнадаг, гэтэл Татварын ерөнхий газар тайлан дээр зөрүү үүсдэг. Бид энэ тохиолдолд татварын байцаагчтай нь уулзаж, нарийн тодруулга авдаг. Тэгэхээр тийм практик байдаг.

Э.Сумъяа: Хоёрдугаарт, тайланд зөрүү үүссэн шалтгааныг Засгийн газар орон нутгийн мэдээг тайландаа оруулаагүйгээс зөрүү үүссэн гэдэг тайлбар хэд хэдэн төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, хандивын зөрүү үүссэн шалтгаан болгож бичсэн байна. Татварын ерөнхий газар үүнийг хүлээн зөвшөөрч байгаа юм уу? Дараа нь бид энэ асуудлыг нухацтай авч үзэх гээд байна.

Н.Эрдэнэцог: Ажлын явцад, тухайлбал хураамж, үйлчилгээний шимтгэл дээр их зөрүү гардаг. Засгийн газрын хувьд орон нутагт төлсөн татвар, төлбөрүүдийг тайлагнахад хүндрэлтэй байдаг нь харагдсан. Өөрсдөө үүнийг хүлээн зөвшөөрч байгаа гэж ойлгож байгаа. Тухайлбал, тохируулга хийхэд Засгийн газар талдаа 330 тэрбум төгрөгний залруулга хийсэн бол, компани талдаа 880 тэрбум төгрөгний залруулга хийсэн. Энэ нь юуг хэлээд байна вэ гэхээр аль аль тал дутуу тайлагнадаг, бүртгэлийн систем учир дутагдалтай байгааг харуулж байна.

Н.Дорждарь: Тэгэхээр эндээс дүгнэхэд тэр тайлбарлагдаагүй зөрүү нь 1.1 тэрбум төгрөг байна, гэтэл тайлан дээрээ та бүхэн 339 сая төгрөгний тайлбарлагдаагүй зөрүү үлдсэн гэж бичээд байна. Энэ олон тоонууд хүмүүсийн толгойг эргүүлээд байна. Энэ цэвэр зөрүү гэж байх нь өөрөө ямар ч утга учир алга байна, яахав статистик гэдэг утгаараа байж болох л юм.

Н.Эрдэнэцог: Үүнийг залруулж болно л доо.

Л.Отгонцэцэг: Миний ойлгосноор тэр Засгийн газар нь 385 сая төгрөгийг хүлээж авсан, гэхдээ компани талдаа нотлогдохгүй байна, харин компани талдаа тэр 525 сая төгрөгийн зөрүү байна, энэ хоёрын нийлбэр нь цэвэр зөрүү юм уу гэж ойлгосон зөв үү.

Н.Эрдэнэцог: Үгүй. Засаг талдаа 385 сая, компани талдаа 724 сая төгрөгний зөрүүнүүд тайлбарлагдаагүй үлдсэн гэж ойлгох хэрэгтэй. Тэр цэвэр зөрүү гэдэгт нэг их ач холбогдол өгсний хэрэггүй. Яагаад гэхээр бид асар олон хүснэгт, тооцоолол хийдэг учраас бүх тоонууд эргээд мөргөж байна уу гэдгийг хянах үүднээс тэр цэвэр зөрүү гэдгийг гаргаж ирсэн. Бидний дотроо ашигладаг хяналтын хүснэгт гэж ойлгож болно.

Б.Осоргарав: Гэхдээ энэ цэвэр зөрүү гэдгээрээ байж байхад буруугүй зүйл гэж бодож байна. Учир нь Засаг талдаа илүү төлөлттэй байгаа, компани талдаа дутуу төлөлттэй байгаа гээд энэ хоёрын балансаар тайлбарлагдаагүй үлдсэн цэвэр зөрүү гэж гарсан. Үүнийг бид эцсийн дүндээ шийдвэрлэгдээгүй зөрүү гэж авч үзэх нь зөв юм.

Д.Дамба: Хамгийн сүүлд мөнгөн урсгал гэдэг хүснэгт гаргасан байна. Энэ ямар ач холбогдолтой вэ? Үүнээс юу харах ёстой вэ?

Б.Эрдэнэцог: Мэдээ тайлангийн чанарыг харуулж байгаа юм. Анх бол Засгийн газар нийт орлогоо 1.8 их наяд төгрөг гэж мэдээлсэн бол тохируулгын дараа нь энэ нь 2.1 их наяд төгрөг болох жишээтэй, компаниуд нийт төлсөн дүнгээ 1.3 их наяд төгрөг гэсэн бол тохируулгын дараа энэ нь 2.1 их наяд төгрөг болох жишээтэй. Компани талдаа яагаад ингэж дутуу тайлагнасан дүн харагдаж байна гэхээр аудитад орсон 200 компанийн дунд тайлангаа огт гаргаагүй 58 компани Засгийн газрын тайлангаар орсон. Тэдгээр 58 компанийн татвар, төлбөрийн тайланг гаргуулж, нэггэлд оруулахаар ийм их зөрүү үүссэн байх жишээтэй. Эцсийн дүндээ энэ санхүүгийн урсгал гэсэн хүснэгтээс аудитад орсон нийт 200 компани улсад хэдий хэмжээний татвар төлсөн, улс нь тэдгээрээс хэдий хэмжээний орлого хүлээн авсныг харуулах зорилготой.

Ш.Цолмон: Нэг асуулт байна. Түрүүний хурал дээр дурьдагдсан. Үндэсний аудитын газраас 2011 онд уул уурхайн компаниудаас хүлээж авсан орлогыг 1.2 их наяд төгрөг гэж мэдээлсэн. Манай тайлангаар зөвхөн 200 компанийн дүн 2.1 их наяд төгрөг гэж байна. Энэ зөрүүг та бүхэн судалж үзэв үү? Үндэсний аудитын газар ямар аргачлалаар гаргасан болоод ингэж дутуу байна?

Н.Эрдэнэцог: Бидний зүгээс хурал дээр ер нь ийм байна шүү, зөрүүтэй байдлыг ажлын хэсгээс нягтлах хэрэгтэй гэж мэдээлэл, зөвлөмж маягаар танилцуулсан юм. Бид тэр аргачлалыг бол судлаагүй, амжсангүй.

Н.Дорждарь: Миний мэдэж байгаагаар 2011 оноос л эхэлж Сангийн яам уул уурхайгаас олсон орлогоо тооцож, мэдээлдэг болсон юм байна лээ, өмнөх онуудаа ч нөхөн гаргаж байх жишээтэй. Тэгэхээр Үндэсний аудитын газраасаа илүү Сангийн яамнаас тодруулах нь зүйтэй байх.

Б.Осоргарав: Үндэсний аудитын газар тэр Сангийн яамнаас гаргасан тоог л мэдээлсэн байх гэж бодож байна. Гэхдээ Сангийн яамны энэ мэдээнд хураамж, төлбөр орохгүй байгаа.

Н.Дорждарь: Бас нэг асуулт байна. Энэ 200 компанид Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн томоохон компаниуд бүгд орсон болов уу? Үүнд яаж итгэлтэй байх вэ? Тухайлбал, бараг Оюу толгойн нөөцтэй адил шахуу зэсийн нөөц оллоо гээд л олон улс даяар мэдээлээд байгаа Надмин гэдэг компани байгаа. Гэтэл энэ компани манай тайланд ганц ч удаа хамрагдаагүй байх жишээтэй. Иймэрхүү компаниуд хамрагдахгүй үлдээд байгаа юм биш биз гэсэн зовнил байна.

Н.Эрдэнэцог: Тухайн жилд улсад 40 сая төгрөгнөөс дээш татвар төлсөн компаниуд аудитын нэгтгэлд хамрагдаж байгаа. Яг 200 компанийг хэрхэн сонгосныг мэдэхгүй юм. Ажлын алба үүнд хариулах байх аа. Гэхдээ яах аргагүй аудитад ороогүй, олон улсын хөрөнгийн бирж дээр мөнгө босгож байгаа компаниуд байгаа. Дараагийн нэгтгэлийн ажлаар иймэрхүү олон улсад хөрөнгө босгоод байгаа, Монголд охин компаниуд нь үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын үйл ажиллагааг ил тод болго гэсэн чиглэл өгөхөд үүнийг хийхэд болохгүй зүйл байхгүй. Гэхдээ иймэрхүү компаниуд яагаад нэгтгэлд орохгүй байна гэхээр миний бодлоор том мөнгөнүүд нь тэр гадаадаа яваад байдаг, монголд зөвхөн хайгуул хийж байгаа, зардал их гаргадаг, ашиг олдоггүй, зөвхөн лицензийн төлбөрөө төлдөг гэдэг утгаараа 40 саяын босго давахгүй, аудитын нэгтгэлд орохгүй үлдээд байж болох юм.

Н.Дорждарь: Миний асуугаад байгаа зүйл бол тусгай зөвшөөрөл эзэмшигч 1000 гаруй компани байна, үүний 500 нь манайд тайлангаа ирүүлж байна, үүнээс 200 компанийг нь аудитад оруулж байна. Тэгэхээр үлдсэн 800 компани нь том уу, жижиг үү гэдэг дээр үнэлгээ хийхэд хүндрэлтэй болчихоод байна. Муугаар хэлэхэд Эрдэнэт ХХК-ийн тайланг Засгийн газар мартаад ч юмуу тайландаа оруулаагүй бол аудитад орохгүй болох нь ээ. Үүнийг яаж цэгцлэх вэ гэдэг дээр л асуудал урган гарч байгаа юм.

Ш.Цолмон: 200 компанийн сонгосон аргачлалын тухайд жил бүр бид Засгийн газрын тайланд үндэслэдэг. Эндээс 40 сая төгрөгөөс дээш татвар төлсөн компаниудыг автоматаар сонгоод, дараа нь компанийн зүгээс тайлангаа гаргасныг нь сонгох гэх мэтээр хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр аудитад орох компаниудыг сонгож авдаг. Хэрхэн сонгосон талаараа байнга ажлын хэсгийн гишүүд рүү имэйлээр мэдээлж, хариу хүсдэг. Ийм байдлаар явж ирсэн. Цаашид мэдээж тэр үлдсэн байх магадлалтай томоохон компаниуд руу анхаарч ажиллах хэрэгтэй. Аудитад орох компанийг сонгохдоо ганцхүү баталгаатай мэдээлэл дээр тулгуурлах нь зүйтэй.

Н.Дорждарь: Сумъяа гуайд хандаж санал тавьмаар байна. Ашигт малтмалын газар дээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдын мэдээлэл байна, ОУИТБС дээр ил тод байдлын тайлангаа гаргасан компаниудын мэдээлэл байна, Засгийн газрын бас мэдээлэл байна, ингээд энэ бүгдийг ашиглаад бид нягталж үзэх хэрэгтэй. Үнэхээр тэр 500 компани үйл ажиллагаа явуулаагүй юм уу? Эсхүл татвар, төлбөр төлөөгүй юм уу? Үүнийг нягталж үзээд тайлан дээрээ тайлбар бичих хэрэгтэй.

Д.Дамба: Бид нарын мэдээллээр 400 орчим компани уул уурхайн салбар идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг гэж байгаа юм. Гэхдээ тайлангаас үлдээд байгаа нь үнэн. Бид судлах ёстой. Хоёрдугаарт, хайгуулын компаниуд ихэнх нь ашиг олох нь бага, гэхдээ зардал их гаргадаг, ялангуяа орон нутагт хандив өгөх тохиолдол их байдаг. Дээр нь тэр гадаадад хөрөнгө босгоод байгаа компаниудын асуудал байна.

Ажлын хэсгийн ахлагч Л.Гансүх хуралдаанд орж ирэв.

Г.Чагнаадорж: “Гацуурт” ХХК нь монголын томоохон компаниудын нэг. Энэ газар тариалан эрхэлж буй компаниудаас газрын төлбөр авдаг уу? Хоёрдугаарт, тайланг уншихаар компаниуд газрын төлбөр төлсөн гээд байдаг, улс хүлээж аваагүй байдаг. Энэ ямар учиртай юм бэ?

Б.Мэндбаяр: Газрын төлбөрийн тухайд энэ нь компанийн нийт дүнгээрээ тайлагнагддаг тул уул уурхайн үйл ажиллагаа явуулаад төлсөн газрын төлбөр нь тэд, газар тариалангийн үйл ажиллагаа явуулаад төлсөн газрын төлбөр нь тэд гэсэн мэдээлэл гарч ирэх боломжгүй. “Гацуурт” ХХК-ийн хувьд Сэлэнгэ аймаг руу тодруулга хүсэхэд ийм хэмжээний газрын төлбөр хүлээж аваагүй гээд байгаа, компани нь бол баримтаар үүнийгээ нотлоод байгаа учраас зөрүү үүссэн байгаа.

Н.Баярсайхан: “Улаанбаатар аудит корпораци” ХХК нь манай нэгтгэлийн ажлыг хийх арвин туршлагатай болсон байгаа. Тэгэхээр энэ нэгтгэлийн ажлын явуулахад Засгийн газрын, компаниудын хандах хандлагад ахиц дэвшил гарч

байна уу? Хоёрдугаарт, Цолмон гуайгаас асуух асуулт байна. Тэр тайлангаа гаргаагүй 58 компани аудитын нэгтгэлд орсон, үүнээс болоод их зөрүү үүссэн гэж байна. Энэ 58 компанийн тайланг гаргуулахад ямар арга хэмжээ авсан, эдгээртэй ямар хариуцлага тооцох вэ?

Б.Осоргарав: Ер нь бол бас ч гэж 4 жилийн өмнө анх тайлангийн нэгтгэл хийж байсныг бодоход ойлголт нь сайжирч байгаа. Нэг том бэрхшээл бол уур уурхайн компаниудын нягтлангууд асар их солигддог юм байна. Үүнээс болоод өмнөх ажилтан нь ажлаа хүлээлгэж өгөөгүй, мэдэхгүй байна гэх байдлаар бидний ажилд их хүндрэл учруулдаг. Хоёрдугаарт, энэ жилийн тухайд шинээр аудитын нэгтгэлд орсон 58 компани ил тод байдлын тайлангийн нэгтгэлийн ажлын талаар ямар ч ойлголтгүй байсан. Өмнөхүүд нь харьцангуй мэдлэг, ойлголт сайжирсан байсан.

Б.Мэндбаяр: Засгийн газрын байгууллагуудын хувьд харьцангуй сайн оролцдог. Энэ жил Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар бүтцийн өөрчлөлтөд ороод хариуцсан ажилтан байхгүйгээс мэдээлэл авахад хүндрэлтэй байсан. Хандлага нь бол сайжирч байгаа.

Д.Дамба: Тайланг гаргахад танай аудитын байгууллага хэрхэн ажиллав? Тухайлбал, хэдэн хүн оролцов? Хичнээн зардал гаргав? Ямар хугацаанд хийж гүйцэтгэв? Одоо цаашид үүнээс олон компанийн нэгтгэл хийх бол дангаараа хийхэд хүчин чадал хүрэлцэх үү?

Б.Осоргарав: Гэрээг 2012 оны 7 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан. Ажил нь 8 дугаар сарын 6-ны өдөр эхэлсэн. 3 сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ. Манай компани дангаараа энэ ажлыг хийж гүйцэтгээгүй. Английн Харт Нойрс групптэй хамтарч хийсэн. Үндсэндээ 12 хүн сүүлийн гурван сар бараг хонож ажиллаа. 21 аймаг, 120 гаруй сум, 200 компани, төрийн 20 гаруй байгууллагатай харьцаж ажиллаа. Нэг байгууллагатай нэг удаа харьцаад асуудал цэгцэрдэггүй, хэд хэдэн удаа харилцдаг.

Ш.Цолмон: 58 компанитай хариуцлага тооцох тухайд ажлын алба ямар нэгэн хариуцлага тооцох статус байхгүй. Гол нь ажлын хэсэг, үндэсний зөвлөлд танилцуулаад шийдвэр, зөвлөмж гаргуулаад явдаг. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хариуцлага тооцдог.

Л.Гансүх: Ямар хариуцлага тооцож ирсэн бэ?

Ш.Цолмон: Хуулийн дагуу тайлан гаргаагүй компанид 1-2 сая төгрөгний торгууль тавьдаг.

Л.Гансүх: За өөр асуулт байна уу? Байхгүй бол саналтай хүн байна уу?

Э.Сумъяа: Нэгдүгээрт, нэгтгэлийн тайланд гарч буй тэр шийдвэрлэгдээгүй зөрүү, анхны зөрүүний тайлбарыг сайн хийх хэрэгтэй байна. Үүнийг эцсийн бүлэгт иргэд унших учраас хүнд ойлгомжтой байх талаасаа илүү анхаарах гэсэн санал байна. Хоёрдугаарт, тайлбарлагдаагүй үлдсэн зөрүүг тухайн хариуцсан байгууллагуудаар нь тухайлбал Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газар гэх мэт газруудаар гарын үсэг зуруулж авах гэсэн саналтай байна. Эргээд энэ нь,

рийн байгууллагуудтай хариуцлага тооцох учраас баталгаажуулж авах хэрэгтэй байна. Гуравдугаарт, түрүүний ажлын хэсгийн хуралдааны үеэр танай энсерциумын нэг оролцогч Харт Нойрс лтд компанийн захирал ноён Крисс Иойрс “Үндэсний аудитын газраас 2011 онд уул уурхайн салбараас Засгийн азрын хүлээн авсан татвар, төлбөрийн орлогыг 1.2 их наяд төгрөг гэж мэдэгдсэн” гэж байсан. Гэтэл манай тайлангаар 200 компанийн төлсөн татвар, төлбөр нь 2.1 их наяд төгрөг байна. Энэ зөрүүтэй мэдээллийн учрыг олох талаар ажлын хэсгийн гишүүд анхаарч ажиллаачээ гэсэн саналтай байна.

Н.Дорждарь: Тайлангийн 24 дүгээр хуудсан дээр байгаа шийдвэрлэгдээгүй зөрүүг компани бүрээр, татварын төрөл бүрээр нилээн дэлгэрэнгүй харуулсан байна. Яг үүн шиг эцсийн тайландаа анхны зөрүүг дэлгэрэнгүй байдлаар тайлбарлан харуулах нь их ач холбогдолтой юм болов уу гэж бодож байна. Түүнчлэн, түрүүнд Сумъяа гуай бас хэлсэн. Энэ тайланг энгийн хүмүүст ойлгомжтой байх тал дээр анхаарч нэр томъёоны тайлбар оруулаарай гэж захих байна. Сүүлд нь нэг зүйл хэлэхэд өмнөх хуралдааны үеэр тэр Крисс Нойрс гэдэг аудитор их сонин зөвлөмж хэлсэн. Юу вэ гэхээр “1.8 их наяд төгрөгний орлого орсон байна, за ийм ийм зөрүү үүссэн байна, гэхдээ та бүхэн энэ тоонуудыг нэг их анхаарахгүйгээр уул уурхайгаас орж ирсэн энэ 1.8 их наяд төгрөг юунд зарцуулагдаж байгаад анхаарал хандуулах хэрэгтэй” гэж байсан. Яахав хөндлөнгийн аудитор гэдэг утгаараа та бүхэн ямар санал, дүгнэлт, зөвлөмж өгөх нь та бүхний эрх. Гэхдээ эцсийн тайлан дээр иймэрхүү дүгнэлтийг оруулбал, бидний төлсөн, авснаа нийтэл гэсэн санаачилгын үндсэн утга санаанаас хазайсан дүгнэлт байх болов уу гэж бодож байна.

Н.Баярсайхан: Шийдэгдээгүй зөрүүнүүдийг дан мөнгөн дүнгээр нь илэрхийлсэн байна. Үүнийг нийт дүнд эзлэх хувиар илэрхийлэх хэрэгтэй. Тайлангийн дүгнэлт, зөвлөмжийн хэсэгт нэг санал хэлэх гэсэн юм. Өчигдөр Нээлттэй нийгэм форум дээр 2013 оны төсвийн тухай зөвлөгөөн болсон. Тэр хурал дээр Сангийн яамнаас 2013 онд уул уурхайгаас олох орлогыг 1.2 их наяд төгрөг байхаар төлөвлөсөн байх юм. Иймд тайлангийн дүгнэлт, зөвлөмж хэсэгт манай энэ нэгтгэлийн тайланг Сангийн яам дараа оны төсвийн төсөөлөл хийхдээ ашиглаж байх талаар дурьдаж өгвөл сайн байна.

Д.Дамба: Тайланг уншихаар компани төлсөн гээд байдаг, улс аваагүй гээд ингээд зөрүү үүссэн байх юм. Компани бол төлөөгүй зүйлээ төлсөн гээд өөрийгөө асуудалд оруулах зүйл хийхгүй нь ойлгомжтой. Тэгэхээр тэр зөрүү үүссэн аймаг сумдад асуудал байгаад байна. Ийм байдал гаргахгүй байх дээр бид анхаарч ажиллах ёстой. Мөн энэ нэгтгэлийн ажлыг хийхэд их өргөн цар хүрээг хамардаг тулган баталгаажуулахад их хүч хөдөлмөр зарцуулагддаг нь харагдаж байгаа учраас дараа жилээс аудитын байгууллагын хүчин чадлыг нэмэгдүүлэх, эсхүл хэвдэн аудитын байгууллагатай гэрээлээд ажлыг нь хувааж өгөх гэх мэт байдла зохион байгуулах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Л.Гансүх: За тэгэхээр ямар ч байсан нэгтгэлийн тайланг өмнө нь нэг үг хэлэлцээд, “Улаанбаатар аудит корпораци” ХХК тайланг 11 сарын эхээр да танилцуулах байсан нь хойшлоод өнөөдөр бидэнд эцсийн байдлаар танилцуу байна. Та бүхний саяны хэлсэн саналуудыг тусгаад эцсийн тайланг Үндэсний зөвлөлд танилцуулъя. Үндэсний зөвлөлд танилцуулахаас өмнө оролцогч гуталын ахлагч нар энэ эцсийн хувилбар дээр илүү сайн ажилламаар байна. Т:

сайтар танилцсаны дараагаар гурван талын ахлагч, дээр нь ажлын албаны зохицуулагч Цолмон нар гарын үсэг зурж Үндэсний зөвлөлд танилцуулна шүү.

Би та бүхэнд анхны хурал дээр л сануулж байсан. Энэ санаачилгын ажлаа бүгд хамтраад сайн болгохын төлөө явна, мэдээж гэхдээ төгс төгөлдөр болсон юм байхгүй, олон улсын түвшинд ч тайлангаа яаж сайжруулах вэ гээд толгойгоо гашилгаж л суугаа. Тийм учраас одоогийн хүрсэн түвшингээ хамгаалж ажиллана.

Үндэсний зөвлөлийг 12 сарын 1-нээс өмнө хуралдуулая гэж төлөвлөж байна. Тайланг хэвлэх тухайд энэ их том тайлан учраас хавсралтуудаа CD дээр хуулаад, үндсэн тайлангаа орон нутгийн тайлантай хамт хэвлэх хэрэгтэй. Цаг хугацаа, зардал мөнгө ч хэмнэх байх.

За тэгээд “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн танилцуулгаас гадна Ажлын хэсгийн зүгээс энэ тайлантай холбоотой товч дүгнэлт, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын талаар маш товчхон танилцуулга бас бэлдэж Үндэсний зөвлөлд танилцуулъя.

Харин тэр шийдвэрлэгдээгүй үлдсэн зөрүүнүүд дээр төрийн байгууллагуудаар тайлбар гаргуулах тухайд энэ ажлын Үндэсний зөвлөлийн хурлаас өмнө зохион байгуулж амжихгүй байх гэж бодож байна. Тиймээс тэр зөрүү ямар учраас үүссэн, ямар байгууллагуудтай холбоотойгоор үүссэн гэх мэт тайлбаруудаа аудитын компани гаргаарай.

Хоёрдугаарт, 2012 оны аудитын нэгтгэлд орох компаниудын нэрсийг энэ онд багтаан гаргаж, аудитад орох болсон тухай мэдэгдлийг компаниудад эртхэн мэдээлэх, анхааруулах хэрэгтэй. За дээр нь түрүүнд манай хэд хэдэн гишүүд дурьдлаа. Гадаадын хөрөнгийн бирж дээр мөнгө босгоод байгаа компаниудын асуудлыг яах вэ?

Ш.Цолмон: Төслийн ил тод байдал гэж олон улсад яригдаад байгаа. Энийг судлах хэрэгтэй.

Н.Дорждарь: Энэ бирж дээр мөнгө босгодог асуудал дан ганц Монгол Улсад тохиолдсон асуудал биш юм. Олон улсад бас энэ талаар их ярьж байгаа. Энэ талаар Батжаргал их судалсан байдаг юм билээ.

Л.Гансүх: Ажлын хэсгийн зүгээс хэдүүлээ энэ талаар сайн судлаад, Батжаргалыг урьж мэдээлэл сонсоод, Улсын Их Хурал, ОУИТБС-ын Олон улсын удирдах хороондоо танилцуулж, санал оруулая. За ингээд нэгдүгээр асуудал хэлэлцэж дууслаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын ОУИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд гишүүдийн хуралдаан дээр гаргасан саналыг тусган, эцсийн хувилбарыг оролцогч гурван талын ахлагч, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нар гарын үсэг зурж баталгаажуулан Үндэсний зөвлөлийн хуралдаанаас гаргах шийдвэрийн төслийн хамт 2012 оны 12 дугаар сарын 1-нээс өмнө Үндэсний зөвлөлд танилцуулахаар тогтов.

2. Монгол Улсын ОУИТБС-ын зургадугаар буюу 2011 оны нэгтгэлийн тайланг хийж гүйцэтгэсэн Английн Харт Нойрс лтд, Монголын Улаанбаатар аудит корпораци ХХК-ний консерциумд гэрээт ажлын явц дундын 60 хувийн төлбөрийг шилжүүлэхийг зөвшөөрөв.

3. Монгол Улсын ОУИТБС-ын долдугаар буюу 2012 оны нэгтгэл тайланд хамрагдах компаниудын судалгааг Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Цөмийн энергийн газартай хамтран гаргаж, нэгтгэл тайланд хамрагдах болсон тухай мэдэгдлийг хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын албанд даалгав.

II.ХЭЛЭЛЦСЭН нь: Тайлангийн маягтад өөрчлөлт оруулах тухай ТАН эвслийн санал

Н.Дорждарь: За ТАН эвслийн зүгээс тайлангийн маягтаас зарим нэг нэр төрлийн татвар, төлбөр, хураамжийг хасах тухай асуудлыг судалж үзлээ. Ер нь бол хасч болно. Гэхдээ бид хэд хэдэн компаниуд, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газартай холбогдож энэ хасах гээд байгаа татвар, төлбөр, хураамжуудыг тайлагнахад хүндрэлтэй байдаг уу гэж асуухад тэд ямар ч хүндрэл байхгүй ээ гэж хариулж байгаа юм. Асуудал юун дээр үүсч байна гэхээр бүтэн жилийн хугацаанд янз бүрийн төлбөр төлсөн байдаг, аудитор үүнийг нь шалгах гээд очихоор анхан шатны баримтаа хайх нь хүндрэлтэй байдаг юм байна. Түүнээс биш бүртгэлийн системд асуудалгүй гэж байна. Тэгээд бид юу гэж ойлгож байна вэ гэхээр тайлан нь аль болох бүх татвар, төлбөрүүдийг хамрах хэрэгтэй. Харин аудитын байгууллага бага дүнтэй төлбөрүүдийн хойноос хөөцөлдөхгүй байх нөхцөлийг нь бүрдүүлэх хэрэгтэй. Ийм боломж байгаа гэж ойлгож байгаа. Тухайлбал, анхны нэгтгэлийн тайлан дээр тухайн зөрүү нь нийт үнийн дүнгийн 5 хувиас доош бол үүнийг шалгахгүй гэх жишээтэй шийдвэрлэж болно.

Э.Сумъяа: Төсвийн тухай хууль 2013 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Энэ хуулиар орон нутагт хандивыг зөвхөн боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагад өгнө, өөр ямар ч байгууллагад хандив өгөхгүй гэж заасан байгаа. Харин тэр аудитаар заавал шалгах материаллаг түвшин, өөрөөр хэлбэл 10,000 төгрөгийг 100,000 төгрөг ч юмуу өндөр болгоод өгчихвөл тэр болгон жижиг төлбөрийн хойноос хөөцөлдөхгүй, хялбар болох байх.

Л.Гансүх: За тэгэхээр ерөөсөө ТАН эвслийн саналыг эхнээс нь уншаад, хэлэлцээд явъя.

Автобензин, дизель түлшний онцгой албан татварыг Эрдэнэт, Петроцайна дачин тамсаг гэх мэт хоёр, гуравхан компаниуд өөрсдөө түлшээ оруулж ирээд төлдөг татвар, олборлох салбартай холбоогүй гээд хасч байсан. Гэхдээ Оюу толгой цаашид үнэхээр энэ төрлийн татвар их хэмжээгээр төлөх магадлалтай байгаа юм бол үлдээе.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын өр байгаа, нөхөн төлөгдөх төлөвтэй байгаа гэж байгаа бол үүнийг бусад гэсэн хэсэгт яг энэ хэллэгээр нь үлдээе.

Цөмийн энергийн тухай хуулийн дагуу төлөх тусгай зөвшөөрлийн тэмдэгийн хураамж. Энийг хассан байсныг үлдээе гэсэн саналтай байгаа юм байна. Гэхдээ тэмдэгтийн хураамж бол хураамж шүү дээ. Жижиг юмаар

хөөцөлдөхөө больё. Бид тайлан гаргаад 6 жил болж байна. Гол зүйлүүд рүүгээ анхааръя. Энийг хасдагаараа хасъя. Ойлгоно биздээ.

Торгуулийг хасахгүй үлдээе гэсэн санал оруулж ирсэн байна. Бид торгуулийг үлдээсэн ш дээ. Яагаад хасна гэж ойлгосон юм. Буруу ойлгосон юм шиг байна.

Н.Баярсайхан: Бид Улаанбаатар аудитын санал болгосон анхны хувилбар дээр ажилласан юм.

Автомашин, өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хасах гэснийг үлдээе гэж оруулж ирсэн байна. Хамгийн их тээврийн хэрэгсэлтэй "Оюу толгой" ХХК-ийн жилийн татвар нь 12 сая төгрөг л байсан. Тэгэхээр энийг байлгаж яах юм бэ?

Х.Лхамаа: Уул уурхайн компаниуд тээврээ өөр компаниар хийлгүүлдэг учраас яг энэ төрлийн татвар төлөх нь бага байдаг.

Д.Сэнгэлмаа: Уул уурхайн компаниуд асар өндөр үнэтэй том оврын машинуудыг оруулж ирж, олон улсын өндөр зэрэглэлийн даатгалын компаниудад давхар даатгал хийлгүүлдэг шүү дээ.

Л.Гансүх: За тэгвэл ингэе. Хэрэв та нар энэ татварыг үлдээе гэсэн саналтай байгаа юм бол тэр том оврын машинуудаас авдаг татварыг нь өндөр болгох талаар санал санаачилга гарга л даа. Тэгэхгүй тохиолдолд одоогийн байдлаар 50,000 төгрөгний татвар төлж байгаа бол үүнийг ил тод байдлын тайланд оруулж яах юм бэ?

Н.Баярсайхан: Нэгдсэн тайлангийн хэмжээнд энэ татвар бага харагдаж болно, сумын түвшинд энэ их мөнгөө.

Л.Гансүх: За үлдээе.

Бусад гэсэн хэсгийг хассан байсныг үлдээе гэсэн байна. За энийг дээрх татварын нөхөн төлбөр гэсэн томъёоллоор үлдээе.

Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэсний төлбөрийг хассаныг үлдээе гэсэн байна. Энэ бол роялти биш, төлбөр учраас үүнийг хасах хэрэгтэй.

Л.Отгонцэцэг: Орон нутагт энэ их асуудалтай. Уул уурхайн компаниуд ийм мод бэлтгэдэг юм байна лээ. Бид энэ төлбөрөөр ямар компани мод бэлтгэснийг олж мэдээд, эргээд хариуцлага ярихад хэрэгтэй.

Л.Гансүх: Би энэ талаар хамгийн сайн мэднэ. Та хэдтэй энд хэдэн цаг ч мэтгэлцэж болно оо. Ерөөсөө уул уурхайн чиглэлийн хоёрхон компани л ийм мод бэлтгэх зөвшөөрөлтэй. Өөр ямар ч компани ингэж мод бэлтгэдэггүй, дандаа худалдаж авдаг, энэ төлбөрийн 2011 оны нийт төлбөр нь ердөө 1,200,000 төгрөг байна. Нийт дүнтэй харьцуулахад 0,000001 хувь байна. Энүүгээр яах юм бэ?

Н.Баярсайхан: За тэгвэл хоёрхон компани төлдөг юм бол энд зөрүү үүсэхгүй, тайлангийн маягт дээр байж байхад юу нь болдоггүй юм бэ?

Л.Гансүх: Та бол ерөөсөө бид энэ төлбөрийг үлдээе гэсэн санал оруулсан учраас энийгээ л хамгаалаад үлдэх ёстой гэсэн байдлаар зүтгээд байх юм. Эрүүл ухаанаар жаахан хар л даа. Хуулийн дагуу уул уурхайн компани өөрсдөө мод бэлтгэх хориотой, тэд худалдаж авах ёстой. Харин та хэд хуулиа хэрэгжүүлэх тал дээр ажиллаарай. Тиймээс энэ төлбөрийг хассанаараа явъя.

Ашигт малтмалаас бусад түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны зөвшөөрлийн хураамж. Үүнийг хасъя.

Орон нутагт төлсөн тэмдэгтийн хураамж. Энийг хасъя.

Төрийн байгууллагын бусад байгууллагад өгсөн хандив, дэмжлэг гэдгийг хасъя гэсэн байсныг үлдээе гэсэн байна. За үлдээе.

Н.Дорждарь: Нэг санал байна. Дахин хэлэхэд хасч болноо. Гэхдээ бид иргэдэд аль болох бүрэн мэдээлэл өгмөөр байдаг. Компани бол тайлагнахад асуудалгүй гээд байгаа. Тайлангийн маягт маань үндсэн болон сайн дурын гэсэн хоёр хэсэгтэй. Тиймээс бид компанид аль болох тайлагнах боломжийг нь нээлттэй үлдээх үүднээс тэр сайн дурын гэсэн хэсэгт нь тэр бага дүнтэй татвар, төлбөрүүдийг нь оруулаад өгвөл яасан юм бэ? Дээр нь тайлангийн маягтын үндсэн мэдээлэл, борлуулалтын хэмжээ гэсэн хэсгүүд дутуу бөглөгддөг юм шиг санагдсан. Энэ талаар анхаарах хэрэгтэй.

Л.Гансүх: За тэгье. Саяны хассан бүх татвар, төлбөр, хураамжуудыг тэр сайн дурын гэсэн хэсэгт оруулая. За ингээд хоёрдугаар асуудал хэлэлцэж дууслаа.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Тайлангийн маягтад өөрчлөлт оруулах асуудлаар иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс идэвх санаачлагатай оролцсоныг сайшаав.

2. Гишүүдээс гарсан саналын дагуу бага дүнтэй татвар, төлбөр, хураамжуудыг маягтын сайн дурын хэсэгт оруулж тусган ОУИТБС-ын тайлангийн маягтад өөрчлөлт оруулж, 2013 оноос туршилтын журмаар явуулах саналыг Үндэсний зөвлөлд танилцуулж, зөвшөөрөл авахаар тогтов.

III.ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллах журмын төсөл

Э.Сумъяа: За журам шинэчлэх хэд хэдэн үндэслэл, шаардлага байсан. Нэгдүгээрт, бид өнөөдрийг хүртэл 2007 оны 1 сарын 4-ны өдөр батлагдсан ажлын хэсгийн ажиллах журмыг мөрдөж ирсэн. Үүнээс хойш олон улсын дүрэмд олон өөрчлөлтүүд гарсан. Хоёрдугаарт, ОУИТБС-ын ажлын хэсэг нь гурван талын тэгш төлөөлөлтэй болж, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон. Гуравдугаарт, өнөөг хүртэл бидний хийж ирсэн ажлаа олон нийтэд сурталчлах, талуудын оролцоог идэвхжүүлэх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх гэх зэрэг хэрэгцээ, шаардлагад үндэслэж ажлын хэсгийн ажиллах журмыг шинэчлэн та бүхэнд танилцуулж байна. Хуучин ажлын хэсгийн хуралдааныг танхимд хурал хийдэг байсан бол

шинэчилсэн журмаар цахим хурал хийж болохоор, түүний материалыг албажуулах тухай гэх мэт өөрчлөлтүүд орсон байгаа. (Танилцуулгыг хавсаргав.)

Л.Гансүх: За асуулт байна уу?

Д.Цэрэнжав: Энд Цолмон гуайн ажлын албанаас өөр ажлын алба яригдаад байна уу? Цолмон гуайн ажлын албыг санаачилгын ажлын алба гэж ойлгоод байгаа, гэтэл энд ажлын хэсгийн ажлын алба гэж бичсэн байна. Энэ хоёр өөр юм уу?

Л.Гансүх: Тийм юм байхгүй. Үг үсгийн алдаа байгаа байх. Үүнийгээ засаарай.

Н.Дорждарь: Ажлын хэсэг аливаа нэг асуудал дээр байр суурь нэгдэхгүй бол санал хураавал түүнийг яаж явуулах вэ? За дээр нь хороо, ажлын хэсэг байгуулагдвал үүнийг гурван талын тэгш оролцоотой байхаар тусгаж өгөх хэрэгтэй.

Л.Гансүх: Санал хураах тухайд хугацаа нь тулсан асуудал дээр талууд зөвшилцөлд хүрэхгүй бол санал хураана, санал хураагаад олонхийн гаргасан шийдвэрийг бусад нь дагаж мөрдөнө гэж оруулах хэрэгтэй юм байна. За бас дээр нь нэг асуудлаар нэг удаа хуралдааныг хойшлуулж болно гэж оруулах хэрэгтэй.

Н.Дорждарь: Бас нэг санал байна. Ажлын хэсгийн хурлуудаа дугаарлах хэрэгтэй. Гэхдээ үүнийг заавал дүрэмд оруулах эсэх дээр сайн хэлж мэдэхгүй байна. Хоёрдугаарт, манай санаачилгын лого гэж тусдаа байдаг. Үүнийг ажлын хэсгийн хуралдааны материалдаа стандарт тогтоогоод ашиглах хэрэгтэй.

Э.Сумъяа: Лого ашиглах тухай бусад гэсэн хэсэгт оруулъя.

Н.Баярсайхан: Маргаан, гомдол гарвал үүнийг яаж шийдвэрлэх вэ?

Л.Гансүх: Ажлын хэсгийн гишүүд асуудлаа хэлэлцээд зөвшилцөлд хүрч, эсхүл санал хурааж шийдвэрлэж байгаа тохиолдолд маргаан, гомдол гэж гарах ёсгүй. Харин санал, хүсэлтээ ажлын албанд мэдэгдэж болно. Хэлэлцэх асуудлын тухайд эхлээд ажлын хэсгийн гишүүдэд танилцуулахад энэ асуудлыг хэлэлцэхгүй ээ гэх юм бол санал хураагаад олонхоороо шийдээд явж болно. Үүнийг журамдаа оруулж өгөөрэй.

Д.Цэрэнжав: Ажлын хэсгийн хуралд гишүүд орондоо хүн ирүүлэх тохиолдол их ажиглагдах юм. Үүнийг яаж зохицуулах вэ?

Л.Гансүх: Төрийн байгууллагуудын хувьд дарга нар нь өөрсдөө завгүй бол орондоо хүн суулгаад мэдээлэл авахад болохгүй зүйл байхгүй. Гэхдээ шийдвэр гаргах түвшний чухал хурлуудад өөрөө заавал байх хэрэгтэй. За ингээд өнөөдрийн хуралдаанаа өндөрлөө.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллах журмын шинэчилсэн төслийг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцээд гишүүдийн хуралдаан дээр гаргасан саналыг тусган батлав. Гэхдээ гишүүдийн саналыг

дүрэмд тусган гишүүдэд цахим хэлбэрээр явуулж, саналыг хэрхэн тусгасныг ажлын 3 хоногт багтаан танилцуулсны дараа мөрдөхөөр тогтов.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллах журмыг хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, оролцогч талуудын төлөөллийн ахлагч нарт даалгав.

3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн ажиллах журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Ажлын хэсгийн 2007 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаар баталсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн ажиллах журмыг хүчингүй болсонд тооцов.

Ажлын хэсгийн хурал 17 цагт 10 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч



Л.ГАНСҮХ

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны харилцааны мэргэжилтэн



Б.ДЭЛГЭРМАА